



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2023 оны 10 сарын 25 өдөр

Дугаар А/87

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4 дэх хэсэг, “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөдөлмөрийн дотоод журам”-ын 11.1.1, 11.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төв АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн эзэмшиж буй Говьсүмбэр аймаг дахь орон сууцны барилга байгууламжийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдалтай танилцаж, магадлах ажиллагаа хийх, Замын-Үүд сумын чөлөөт бүс, хилийн бүсэд хийсэн хөрөнгө оруулалтын асуудалтай газар дээр нь танилцаж дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, хуваарь, шаардагдах зардлын төсвийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2. Ажлын хэсгийн ажиллах удирдамжийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

3. Ажлын хэсгийн холбогдох зардлыг зохих журмын дагуу тосцож, дотоод томилолтын зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч /Д.Отгонтуяа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

132013715

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 10 дүгээр сарын 25 өдрийн
А/82 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**ОРОН НУТАГТ АЛБАН ТОМИЛОЛТООР
АЖИЛЛАХ УДИРДАМЖ**

2023 оны 10 дугаар сарын 25

Нэг. Зорилго: "Төв АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн эзэмшиж буй Говьсүмбэр аймаг дахь орон сууцны барилга байгууламжийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдалтай танилцаж, магадлах ажиллагаа хийх, Замын-Үүд сумын чөлөөт бүс, хилийн бүсэд хийсэн хөрөнгө оруулалтын асуудалтай газар дээр нь танилцаж дүгнэлт гаргах ажлыг хийж гүйцэтгэнэ.

Хоёр. Ажиллах газар: Говьсүмэр аймаг, Дорноговь аймгийн Замын-Үүд сум;

Гурав. Ажиллах хугацаа: 2023 оны 10 дугаар сарын 26-27 хооронд, 2 хоног;

Дөрөв. Ажиллах бүрэлдэхүүн: Төрийн өмчийн бүртгэл ашиглалтын хэлтсийн дарга Д.Нарангэрэл, ахлах мэргэжилтэн Б.Мөнхбаатар, мэргэжилтэн Д.Батболд, мэргэжилтэн М.Баярмаа

Тав. Гүйцэтгэх ажил:

- "Төв АЗЗА" ТӨХК-ийн иргэдэд түрээслэж буй орон сууцны барилгыг, эзэмшигч компанийг байлцуулан газар дээр нь нүдээр үзэж танилцах, Орон нутгийн иргэд, удирдлагатай уулзах;
- Замын-Үүд сумын чөлөөт бүс, хилийн бүсэд хийсэн хөрөнгө оруулалтын асуудалтай газар дээр нь танилцаж дүгнэлт гаргах;
- Төрийн өмчийн бүртгэлээс хасч Дорноговь аймгийн өмчид буюу Замын-Үүд сумын Цагдаагийн хэлтэст шилжүүлж байгаа автомашиныг хүлээлцэх;
- Замын-үүд сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газрын данснаас хасах хөрөнгүүдийг үзэх;
- Бусад асуудал;

Зургаа. Орон нутагт ажиллаж ирснээс хойш ажлын 2 өдөрт багтаан тайлан бичиж танилцуулна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын
2023 оны 10 сарын 10-ны өдрийн /10/ дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт

ОРОН НУТАГТ ТОМИЛОЛТООР АЖИЛЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ЗАРДЛЫН ТӨСӨВ

(төгрөгөөр)

Д/д	Аймгийн нэр	Ажлын хэсэг		Ажиллах хүний тос	Ажиллах хоног /кален	Томилолтын зардал	Замын зардал /шатахуун/	Нийт зардал
		Нэр	Албан тушаал					
1	Говь-Сүмбэр	Д.Нарангэрэл Б.Мөнхбаатар	ТӨБАХ-ийн дарга, ахлах мэргэжилтэн,	4	1	472,000.00	82,455.00	554,455.00
2	Замын-Үүд	Д.Батболд М.Баярмаа	мэргэжилтэн	4	1	256,000.00	427,140.00	683,140.00
	ДҮН				2	728,000.00	509,595.00	1,237,595.00

Танилцсан:

Захиргаа удирдлагын хэлтсийн дарга

Н.Ганболд

Хянасан:

Ерөнхий нягтлан бодогч

Д.Отгонтуяа

Боловсруулсан:

Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын
мэргэжилтэн

М.Баярмаа